



ШИВЭЭГОВЬ СУМЫН МЭДЭЭ

2023 оны 03-р сарын 18-наас 03-р сарын 31-ний хооронд
хийгдсэн ажлуудаас



УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



2023 оны 03 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд Аймгийн Онцгой байдлын газарт зохион байгуулагдсан Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын богино хугацааны танхимын сургалтад сумаас 10 албан хаагчид хамрагдаж, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж, хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна. Энэхүү сургалтын гол зорилго нь “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилго, зорилт, үйл ажиллагааны үр дүн, ЗГ-аас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн уялдаа холбооны талаарх мэдлэг эзэмшиж, байгууллагынхаа үйл ажиллагааг болон төлөвлөгөөг энэхүү бодлоготой нийцүүлэх, хэрэгжүүлэх ур чадварт суралцах юм.

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР
АЙМГИЙН ТӨВ ЦЭНГЭЛДЭХ ХҮРЭЭЛЭНД
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ЗОХИОН
БАЙГУУЛАГДСАН “ЭНЭ ЖИЛДЭЭ ЭРҮҮЛ ЖИН
ДЭЭ” АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОЖ, ЭРҮҮЛ
МЭНДИЙН ҮЗЛЭГ БОЛОН АНХАН ШАТНЫ
ШИНЖИЛГЭЭ, ОНОШЛОГООНД АЛБАН
ХААГЧДЫГ ХАМРУУЛСАН.



УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТРАН

АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА.

2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан сумдын засаг дарга, агентлаг, төрийн үйлчилгээний болон орон нутгийн өмчийн байгууллагуудтай гэрээ байгуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах арга хэмжээнд оролцож 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, хамтран ажиллах гэрээг байгууллаа.





УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ



- ✚ Эхийн иргэний үнэмлэхний нотариатаар батлуулсан хуулбар. Иргэний үнэмлэхний хаягийн зөрүүтэй бол байнга оршин суугаа хаягийн лавлагаа
- ✚ Бүх хүүхдийн төрсний гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар, насанд хүрсэн хүүхдийн хувьд /16-аас дээш/ төрсний гэрчилгээнээс гадна иргэний үнэмлэхний нотариатаар батлуулсан хуулбар /нэг цаасан дээр иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг хамтад канондож нотариатаар батлуулах/
- ✚ Төрсний гэрчилгээг хаяж гэж үрэгдүүлсэн бол Улсын бүртгэлийн байгууллагаас болон E-mongolia-гаас лавлагаа авах
- ✚ Өргөдөл, /Өргөдлийн толгойг "Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт.....аймгийн...сумын...-р багийн Засаг даргаар уламжлан хүсэлт гаргах нь" гэж бичнэ, товчлохгүй хар өнгийн балаар өргөдлийн загварын дагуу бичих
- ✚ 1-р одон авах эхчүүд 2-р одонгийн үнэмлэхний нотариатаар батлуулсан хуулбар
- ✚ 2 хувь цээж зураг

Сумын “Алдарт эх”-ийн 1 болон 2 дугаар одон шинээр авах иргэдийн материалыг 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл бүртгэн авч, сумын 1-р багийн “Алдарт эх”-ийн 2 дугаар зэргийн одонгийн болзол хангасан 7 эх, 2-р багийн “Алдарт эх”-ийн 1 дүгээр зэргийн одонгийн болзол хангасан 1 эх, 2-р зэргийн одонгийн болзол хангасан 4 эх буюу сумын хэмжээнд нийт одон шинээр авах 12 эхийн материалыг хүргүүлээд байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР



Аймгийн Хөдөө аж ахуйн газарт 7 хоног бүрийн 3 дах өдөр том малын хорогдолын мэдээ болон өвсний нөөцөд байгаа үлдэгдлийн мэдээг тогтмол өгч байна. Сумын аюулгүйн нөөцөд 60 боодол өвс, 20 шуудай тэжээлийн үлдэгдэлтэй байна. Хаврын тариалалттай холбогдуулан хүлэмж авах хүсэлтэй 7 иргэн хүсэлтээ гаргасан бөгөөд хүсэлтийг шийдвэрлэхээр ажиллаж байна. Тариалан эрхлэгч иргэд үрсэлгээ хийж эхлээд байгаа бөгөөд эхний ээлжинд 500 ширхэг /чинжүү, лооль/ үрсэлгээ хийгдээд байна. Энэ онд ургацын хувийг өмнөх оноос нэмэгдүүлэхээр ажиллаж байна.





ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

- ❖ Иргэдийн өргөдөл, гомдлыг цахим хүсэлтийн дагуу хүлээн авч, 5 иргэдийн өргөдлийг холбогдох бичиг баримтыг шалган шийдвэрлэсэн.
- ❖ Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл ирүүлсэн талбайнуудтай давхцаж буй эзэмшлийн газруудын талаарх мэдээллийг гаргаад байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл ирүүлсэн талбайнуудтай давхцаж буй эзэмшлийн газрууд нь 4 байршил байна.
- ❖ Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 10 иргэнд газар эзэмших, өмчлөх талаар зөвлөгөө мэдээлэл өгч газрын төлбөрийн нэхэмжлэх, хянан баталгааны мэдэгдэх хуудас зэргийг хүргүүлээд байна.



ИРГЭН ТАНЫ 2022 ОНД ӨГСӨН САНАЛААР 2023 ОНД ДАРААХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУДЫГ ХИЙНЭ:



Энэ мөнгөйг
таны саналаар
зарцуулна

2023

БАТЛАГДСАН
ОНХС-ийн ТӨСӨВ

1,106,937.9
тэрбум төгрөг

- ✓ 3-р цэцэрлэгийн хашааг шинэчлэх- **159.931,8** сая төгрөг
- ✓ Сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил- **354.637,2** сая төгрөг
- ✓ Нийтийн эзэмшлийн байр болон гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах /2 газарт/- **195.0** сая төгрөг
- ✓ Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэгийн тоог нээгдүүлэх сэргээн засварлах- **35.868,9** сая төгрөг

МАНАЙ СУМЫН ОНХС-ийн ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭРХЭН ҮНЭЛЭГДЭЖ ИРСЭН БЭ?

Шивээговь сумын 2016-2022 оны ОНХС-ийн үнэлгээ



Сайн үнэлүүлсэн сум "урамшуулал" нэмж авдаг

Манай сум "үлсад хэдэд эрэмбэлэгдэж байсан бэ?"

Он	Урамшуулал /тог/
2017	106
2018	21
2019	10
2020	87
2021	73
2022	37



Та QR кодыг уншуулж "ОНХС" апп-ийг гар утсандээ суулгаж ОНХС-ийн 2024 оны саналаа өгнө үү.





ИРГЭН ТАНЫ 2022 ОНД ӨГСӨН САНАЛААР 2023 ОНД ДАРААХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУДЫГ ХИЙНЭ:



Энэ мөнгөйг
таны саналаар
зарцуулна

2023

БАТЛАГДСАН
ОНХС-ИЙН ТӨСӨВ

1,106,937.9

тэрбум төгрөг

- ✓ Хогны машин худалдаж авах- 110,000.0 сая төгрөг
- ✓ Боловсролын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүнд тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх- 50,000,0 сая төгрөг
- ✓ 2024 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын зураг төсвийн зардал- 40,000,0 сая төгрөг

ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

- ↓ Байгаль орчин, эрүүл ахуй, орчны бохирдлыг бууруулах "Хоггүй сум" арга хэмжээ- 27,500,0 сая төгрөг
- ↓ "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжих арга хэмжээ- 45,000,0 сая төгрөг
- ↓ Хүүхэд, залуучууд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих арга хэмжээ- 9,000 сая төгрөг
- ↓ Төрийн албан хаагчдын орчин нөхцлийг сайжруулах арга хэмжээ- 20,000,0 сая төгрөг
- ↓ Малын тоо толгойн албан татвараас малчдад зориулсан арга хэмжээ- 45,000,0 сая төгрөг
- ↓ Үндэсний баяр наадмын зардал- 5,000,0 сая төгрөг
- ↓ Гамшгийн эрсдлийг бууруулах арга хэмжээний зардал /шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах/- 10,000,0 сая төгрөг



БОЛОВСРОЛЫН ТАЛААР

Улаанбаатар хотод зохиогдсон Дэлхийн усны өдөрт зориулан Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдаж буй **“ЦЭНХЭР АЛТ”** хэлэлцүүлгийн хүрээнд **“ӨӨРЧЛӨЛТИЙГ ХУРДАСГАЯ”** өдөрлөгт сумын ЕБС-н эко клубийн 7 сурагч, удирдагч багшийн хамт оролцлоо.

Өдөрлөгийн хүрээнд:

1. "Олон дүрст ус" илтгэл
2. Bamboo театрын "Бидний эрхэм анд-Ус" үзүүлбэр
3. ХААИС-ийн экологийн тэнхимийн танилцуулга
4. Усны үнэ цэнэ гар зургийн үзэсгэлэн
5. Усны эх-ОЙ оролцоог дэмжсэн тоглоом
6. Цэнгэг ус нөөцийн газрын лабораторид усны найрлага, орчин тодорхойлох дадлага ажил
7. Байгалийн "Аквариум" болон музейн үзмэрүүд зэрэг арга хэмжээ зохиогдсон.





БОЛОВСРОЛЫН ТАЛААР



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУД БОЛОН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРГАА, АЖ АХУЙН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН ДУНД ЗОХИОН ЯВУУЛДАГ “НӨХӨРСӨГ УУЛЗАЛТ -2023” ТЭМЦЭЭН 15 ДАХЬ ЖИЛДЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.


“Нөхөрсөг уулзалт -2023” тэмцээний үеэр аймаг орон нутагтаа олон жил үр бүтээлтэй ажилласан албан хаагчдыг шагналаа. Сумын ЕБС-аас 6 албан хаагч тус шагналаар шагнагдсан болно.



БОЛОВСРОЛЫН ТАЛААР

Улаанбаатар хотноо зохиогдсон “өсвөр
үеийнхний эрүүл мэндийг дэмжихэд сургуулийн
эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эцэг эх,
асран хамгаалагчдын хамтын ажиллагаа
бэхжүүлэх нь” өдөрлөгт сургуулийн сэтгэлзүйч
оролцлоо.

2023 онд Сумын ЕБС-д сэтгэлзүйч ажиллаж эхэлснээс хойш тодорхой хэмжээгээр сурагчдын сэтгэл санааны гутрал буурч, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хандлагатай байна.





БОЛОВСРОЛЫН ТАЛААР



Сургуулийн хүрээнд Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн төлөвлөгөөний дагуу **"Надад туршлага байна 2"** ажлын байран дээрх туршлага солилцох үйл ажиллагаа амжилттай боллоо. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд бага, дунд, ахлахын багш нарын залгамж холбоо сайжрах суурь тавигдаж, хэнээс яг ямар чиглэлээр суралцах, сонирхлын бүлгээрээ хэнтэй хамтарч ажиллаж, харилцан суралцах боломжтойгоо олж харсан шинэлэг ажил болж өндөрлөлөө.



ЦАГДААГИЙН ХЭСЭГ



Хүлээн авч шалгасан гомдол мэдээлэл, хэргийн талаар :

Сүүлийн 14 хоногийн байдлаар иргэд, ААН байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 3, зөрчлийн шинжтэй 6 гомдол мэдээлэл хүлээн авч материалжуулан шалгасан байна.

Зөрчлийн 6 гомдол мэдээллийг хүлээж авч шалагсанаас 4 гомдол мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдэж, 2 гомдол мэдээлэлд зөрчлийг хэрэг нээсэн.

Гэмт хэргийн шинжтэй 1 гомдол мэдээллийг хаах саналтай Аймгийн прокурорын газарт хүргүүлсэн.



ЦАГДААГИЙН ХЭСЭГ



Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр

Сумын 1,2-р багийн нутаг дэвсгэрт нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явганаар болон хөдөлгөөнт эргүүлийг тогтмол хийн ажиллаж байна. Эргүүлийн хугацаанд гудамж талбайд согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэж биеэ авч явах чадваргүй болсон 12 иргэнийг ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн. Цагдаагийн хэлтсийн ЭСББайранд 8 иргэнийг хүлээлгэн өгсөн,

Монгол улсын зөрчлийн тухай хуулийн 5.1.1, 5.1.2, 6.3.1 дугаар зүйл заалтуудыг зөрчсөн 13 иргэнийг 140.000 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Зөрчил гаргасан иргэдийг хэсгийн байранд дуудан ирүүлж дахин зөрчил гаргахгүй байх талаар баталгааг авч эрх зүйн зөвөлгөөг өгч ажилласан.

Хутга мэс зодооны хэрэгсэл биедээ авч явсан 2 иргэний бие үзлэг шалгалтыг хийж 2 хутга хураан авч хариуцлага тооцон ажилласан.



ЦАГДААГИЙН ХЭСЭГ



Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн, 21 тээврийн хэрэгсэлийн жолоочид Зөрчилийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 20 жолоочийг 760.000 төгрөгөөр торгож ажилласан.

Уусан бол бүү жолоод нэгдсэн эргүүлийг 5 дахь өдөр хариуцсан сумын нутаг дэвсгэрт зохион байгуулан ажиллахад согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон 2 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж 800.000 торгох арга хэмжээ авч ажилласан.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Торгууль нөхөн төлүүлэлт” арга хэмжээний хүрээнд 6 жолоочийн 90,000 төгрөгний торгуулийг нөхөн төлүүлж ажилласан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ



Түргэн тусламжийн дуудлагын төрөл, тоо хэмжээ

Амбулаторийн үйлчилгээ

Амбулаторийн үзлэг -188

Үүнээс: Идэвхитэй хяналт-
22

Урьдчилан сэргийлэх
үзлэг-18

Нярайн гэрийн эргэлт-8

Томуу- 18

Эрүүл мэндийн
даатгалаар оношлогоо
шинжилгээ, өдрийн
эмчилгээ зэргээр тусламж
үйлчилгээ явуулж байна.

Нийт дуудлага- 36

Алсын дуудлага- 2

Төвийн дуудлага- 34

Том хүн- 16

Хүүхэд- 20

Осол гэмтэл-0

Хөхний эрт илрүүлэгийн
үзлэг- 22

СТАЦИОНАРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хэвтэн эмчлүүлэгчид нийт-
22

Дотор- 16

Хүүхэд- 6

Халдварт-0



СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА

2023 оны сургалт сурталчилгаа төлөвлөгөний дагуу мэдээ мэдээлэл, зөвлөмжийг цаг тухай бүрт нь олон нийтийн сүлжээгээр мэдээллэдэг. Сүүлийн 14 хоногт 5 өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг байршуулсан. Иргэдийн хандалтын хувь 66%-тай байна.



СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА

Шивээговь сумын Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн боловсрол олгох раге хуудас болон шивээговь нэгдсэн зарын дээр ард иргэдэд эрүүл мэндийн мэдээ, нийгмийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан богино хэмжээний бичлэг, мэдээлэл зэргийг цаг алдалгүй оруулж ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний материалын хүрэлцээтэй байна. Эм тарианы хангалт хийгдсэн одоогийн байдлаар хүрэлцээтэй байна.



АНХААРАЛ ХАНДУУЛСАН
ЯВДАЛД БАЯРЛАЛАА.

